

## СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, СУДЛАГДСАН БАЙДАЛ:

Эмчилгээний өндөр идэвхитэй, аюулгүй чанарын баталгаатай эм, биобэлдмэл (цаашид “эм” гэх)-ийг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хүн амыг шаардлагатай эмээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангаж, түүний зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь Монгол улсын төрөөс баримтлах бодлогын эрхэм зорилго мөн.

Иймд хүн амын өвчлөлийн оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэхэд аюулгүй эм, биобэлдмэл хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх болон бүртгэлийн дараах аюулгүй байдлыг хянах үйл ажиллагааг тогтмолжуулах асуудал нэн чухал юм. Монгол улсад эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх тогтолцоог 2005 оноос эхлэн бүрдүүлж, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, ЭМС-ын 2013 оны 415 дугаар тушаалаар тус тус зохицуулан хэрэгжүүлж байна.

Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн байгууллагын эмийн гаж нөлөөний мэдээллийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа хэдий ч, эмийн гаж нөлөөг мэдээлэх хуудас чанарын шаардлага хангахгүй, гаж нөлөөг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай мэдээллүүд дутуу бөглөгдсөн байх зэрэг нийтлэг дутагдал гарч байна.

Иймд эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэхийн ач холбогдлын талаар сургалт явуулах, ноцтой гаж нөлөөний дохио илрүүлэх арга зүйд сургах, тэднийг эмийн аюулгүй байдлыг бэхжүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор уг судалгааг хийж байна.

Сүүлийн жилүүдэд их хэмжээний эмийн бүтээгдэхүүн зах зээлд шинээр нэвтэрч, олон мянган иргэд эмийн хүсээгүй гаж нөлөөний улмаас эрүүл мэнд, эдийн засгийн хувьд хохирол амсахын хажуугаар байнгын хөгжлийн бэрхшээлтэй болох, төрөлхийн гаж хөгжил үүсэх зэрэг хүндрэлүүд нэмэгдэж байна. Иймээс Дэлхийн эрүүл мэндийн байгууллага нь олон улсын хэмжээнд эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээний сан бүрдүүлж, гаж нөлөөг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж байгаа билээ.

Тухайлбал: 1969-2002 онд 33 жилийн хугацаанд АНУ –ын эмийн гаж нөлөөний мэдээллийн санд нийт 2,3 сая гаж нөлөөний тухай мэдээлэл ирсэн ба тэдгээрийн 6000 нь зах зээлд нэвтэрсэн эмтэй холбоотой байжээ. Уг мэдээллийн дагуу тухайн эмийн гаж нөлөөг судлан эмийн шошго, заавар дээр гаж нөлөөний анхааруулгыг нэмж оруулах, 75 эмийг аюулгүй байдлын улмаас зах зээлээс эргэн татах, 11 эмийг зөвхөн онцгой тохиолдолд хэрэглэх буюу эмийн түгээлтэнд хязгаарлалт тогтоох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Монгол улсад эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх журмыг 2006 онд анх батлан, хоёр, гуравдугаар шатлалын эмнэлгүүдэд эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх үйл ажиллагааг “Эмийн эмчилгээний хороо” зохион байгуулахаар тусгасан.

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 378 тоот тушаалаар “Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх журам болон эмийн гаж нөлөөг мэдээлэх хуудас”-ыг шинэчлэн баталсан. Уг тушаалын дагуу эмийн гаж нөлөөг эмнэлгээс гадна эмийн үйлдвэр, эм хангамжийн байгууллага, эмийн сан бүртгэн, мэдээлж байхаар журамласан. Одоогийн байдлаар Эрүүл мэндийн сайдын 2015 оны 89 дугаар тушаалаар эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн үйл ажиллагааг зохицуулж байна.

**СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:**

Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн тогтолцоо, бодлогын хэрэгжилт, түүний үр дүнг тооцох

**СУДАЛГААНЫ ЗОРИЛТ:**

1. Эмнэлгийн мэргэжилтэн, эмийн сангийн ажилчид эмийн гаж нөлөөний талаар иргэдэд мэдээлэл өгч буй үйл ажиллагаанд үнэлгээ хийх
2. Иргэдийн эмийн гаж нөлөөний талаарх мэдлэг, хандлагыг тодорхойлох
3. Эмийн хэрэглэх зааврын хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийх

**СУДАЛГААНЫ ТААМАГЛАЛ:**

Эмнэлгийн мэргэжилтнүүд эмийн гаж нөлөөг тогтмол бүртгэж хэвшээгүй.

**СУДАЛГААНЫ ШИНЭЛЭГ ТАЛ, АЧ ХОЛБОГДОЛ:** Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн тогтолцоонд тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, сайжруулах санал, зөвлөмж боловсруулан шийдвэр гаргагчдад хүргэж байгаагаараа ач холбогдолтой.

**ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН:**

Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн тогтолцоо, бодлогын хэрэгжилтэд тулгамдаж буй саад, бэрхшээлийг даван туулах санал, зөвлөмжийг шийдвэр гаргагч нарт хүргэнэ.

**СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ:**

Судалгаанд тоон болон чанарын судалгааны аргыг ашиглана.

**ХАМРАХ ХҮРЭЭ:**

Судалгаанд төр ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, эмийн санд тухайн агшинд ажиллаж байгаа эмнэлгийн ажиллагсад, эмнэлэг, эмийн сангаар үйлчлүүлж буй иргэдийг хамруулна.

**СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙ:**

Олон улсын судалгааны ёс зүйн дүрмийн дагуу судалгаанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгээр үйлчлүүлэгсдийн овог, нэр, хаяг, ажлын газар зэрэг хувийн мэдээллийг нууцалсан болно.

**СУДАЛГААНЫ БЭРХШЭЭЛ, ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ:**

Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн тогтолцооны талаар бие даасан анхны судалгаа тул судлах материал ховор байв.

Цаашид эмийн гаж нөлөөний талаар Эрүүл мэндийн яам, мэргэжлийн хяналтын болон эрүүл мэндийн байгууллагуудад бүртгэгдсэн иргэдийн гомдлууд, шүүхийн байгууллагад шалгагдсан, ял шийтгүүлсэн хэргүүд, эмийн гаж нөлөөний талаар олон нийтийн цахим сүлжээнд тавигдсан мэдээллүүд, ажиглалтын аргаар эмнэлгийн тасаг, нэгжид гарсан гаж нөлөөний тохиолдлыг илрүүлэх гм олон эх үүсвэрээс цуглуулсан мэдээллийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмийн гаж нөлөөний мэдээллийн сангийн мэдээлэлтэй тулган үзэх, харьцуулан судлах шаардлагатай нь харагдсан.

**МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА БА МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ:**

Тоон болон чанарын судалгааны аргуудыг ашиглан судалгааны мэдээлэлд боловсруулалт хийсэн.

Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад болон үйлчлүүлэгсдээс тусгайлан боловсруулсан асуумжийг өөрсдөөр нь бөглүүлэх аргаар мэдээллээ цуглуулан тоон судалгааны аргыг ашиглан боловсруулалт хийсэн. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсадын бөглөх асуумж нь олон сонголт бүхий 29 асуулттай, түүний 2 асуултыг нээлттэй бөглөхөөр; иргэдэд зориулсан асуумж нь хариултаас хамааран 2 эсвэл 4 асуултад хариулахаас 1 нь нээлттэй бөглөх сонголтыг агуулсан байлаа. Асуумж судалгааг 2018 оны 09 сарын 03-28 ны өдрүүдэд авсан болно.

Асуумж судалгааны мэдээлэлд SPSS-2.0 болон Excel программуудыг ашиглан дескриптив болон статистикийн энгийн шинжилгээний аргыг ашиглан үр дүнгийн шинжилгээ хийсэн.

### СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ:

Судалгаанд нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул зэрэг 6 дүүргийн эрүүл мэндийн төв, төрийн өмчит болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, нийтийн эмийн сангууд хамрагдав.

### СУДАЛГААНЫ НЭГЖ, ТҮҮВЭРЛЭЛТИЙН ТОО:

Судалгааны нэгжээр тухайн агшинд эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байсан эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгээр үйлчлүүлж байсан иргэдийг сонгосон. Эрүүл мэндийн байгууллагын амбулатори болон стационарын ажиллагсад ба үйлчлүүлэгчдийн 2017 оны статистик үзүүлэлтийн тоог эх олонлогоор авч, судалгааны түүвэрлэлтийн тоог дараах томъёогоор байгууллага бүрээр тооцоолон тогтоосон бөгөөд энэхүү түүвэрлэлт 95.4 %-ийн магадлалыг хангана.

$$n = \frac{t^2 \cdot w \cdot (1-w) \cdot N}{N \cdot \Delta_p^2 + t^2 \cdot w \cdot (1-w)}$$

t - Баталгааны коэффициент буюу Стьюдентийн тархалтын критик утга. Итгэх магадлал нь 95.4% байхад t=2 байна.

w\*(1-w) - харьцангуй хэмжигдэхүүний дунджаасаа хазайх хазайлтын квадрат буюу дисперсийг оролдог тоо ба 0.25-тай тэнцүү байна.

N- Эх олонлогийн хэмжээ буюу тухайн эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад, үйлчлүүлэгсдийн тоо  
Делта - Алдааны хязгаар 0.05 байна.

n- Түүврийн хэмжээ

### СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Судалгаанд нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул зэрэг 6 дүүргийн эрүүл мэндийн төв, төрийн өмчит болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, нийтийн эмийн сангуудаар 2018 оны 09 сарын 03-28-ны өдрийн хугацаанд үйлчлүүлсэн 300 иргэн, улсын эмнэлгийн 15, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 78 мэргэжилтэн, эмийн сангийн 113 эм зүйч, эм найруулагч судалгаанд хамрагдсан.

#### Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтан болон иргэдийн тоо (дүүргээр)

№	Дүүргийн нэр	Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтан		Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгч	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Баянгол	31	15	57	19
2	Баянзүрх	28	14	58	20
3	Чингэлтэй	40	19	43	14
4	Сүхбаатар	28	14	43	14


5	Сонгино-Хайрхан	36	18	57	19
6	Хан-Уул	43	20	42	14
	<b>Дүн</b>	<b>206</b>	<b>100</b>	<b>300</b>	<b>100</b>

Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хамгийн их буюу 20% (42) нь Хан-Уул дүүрэг, үйлчлүүлэгчдийн хамгийн их буюу 19% (57) нь Баянгол, Баянзүрх, Сонгино-Хайрхан дүүргийн харьяалалтай байв.

### Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтан ( мэргэжлээр)

№	Мэргэжил	Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтан	
		Тоо	Хувь
1	Эм найруулагч	74	36%
2	Эм зүйч	42	21%
3	Их эмч	44	21%
4	Сувилагч	46	22%
	<b>Дүн</b>	<b>206</b>	<b>100</b>

### Зураг 1. Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтан ( мэргэжлээр)




Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хамгийн их буюу 36%(74) нь эм найруулагч ба эм зүйч, их эмч, сувилагч нар тус бүр 21-22 %-ийг эзэлж байна.

### Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтан ( байгууллагаар)

№	Байгууллагын төрөл	Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтан	
		Тоо	Хувь
1	Төрийн өмчит эмийн сан	4	2%
2	Хувийн хэвшлийн эмийн сан	113	55%
3	Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллага	11	5%
4	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага	78	38%
	<b>Дүн</b>	<b>206</b>	<b>100</b>


Зураг 2. Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтан (байгууллагаар)



Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны талаас илүү буюу 55%(113) нь хувийн хэвшлийн эмийн санд, 38% (78) нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад, 7% нь төрийн өмчит эрүүл мэндийн байгууллага болон эмийн санд ажилладаг байна.


Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтнууд бүгд эмийн гаж нөлөө болон түүний улмаас хүний биед учрах хор хөнөөлийг мэддэг, энэ талаар мэдэх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн байна.

Зураг 3. Иргэдийн эмийн гаж нөлөөний талаарх мэдлэг (хувиар)




Иргэдийн 85% нь эмийн гаж нөлөөний талаар мэддэггүй байна.

**Зураг 4. Иргэдээс эмийн гаж нөлөөтэй холбоотой гомдол хүлээн авч байсан эрүүл мэндийн ажилтан (хувиар)**




Судалгаанд хамрагдагсан эрүүл мэндийн ажилтны дийлэнх буюу 57% нь иргэдээс эмийн гаж нөлөө илэрсэн талаар гомдол хүлээн авч байгаагүй, зөвхөн 20% нь энэ төрлийн гомдол хүлээн авсан байна.

**Зураг 5. Иргэдэд эмийн гаж нөлөө илэрсэн тохиолдолд мэдээлэх талаар зөвлөгөө өгсөн эрүүл мэндийн ажилтан (хувиар)**



Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны 14% нь эмийн гаж нөлөө илэрсэн үед мэдээлэх шаардлагатай гэж иргэдэд зөвлөсөн байна.

Зураг 6. Эмийн шар хуудсыг бөглөх талаар зөвлөсөн эрүүл мэндийн ажилтан (хувиар)



Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны дийлэнх буюу 70% нь иргэдэд эмийн шар хуудсыг бөглөх талаар зөвлөөгүй байна.

Зураг 7. Иргэдэд эмийн гаж нөлөөний талаар мэдээлэл өгдөг эрүүл мэндийн ажилтан (хувиар)




Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажиллагсдын 25% нь эмийн гаж нөлөөний талаар иргэдэд зөвлөгөө өгч байсан бол 72%-нь заримдаа зөвлөгөө өгч, 3% нь үгүй гэсэн байна. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад үйлчлүүлэгчид эмийн гаж нөлөөний талаар мэдээлэл харилцан адилгүй өгдөг байна

Зураг 8. Эмийн гаж нөлөөний талаар лавладаг иргэд (хувиар)



Судалгаанд хамрагдсан иргэдийн 7% нь эрүүл мэндийн ажилтнуудаас эмийн гаж нөлөөний талаар асуудаггүй нь эмийн гаж нөлөөний талаар иргэдийн мэдлэг дутмаг байдагтай холбоотой байж болно.


Зураг 9. Иргэдийн эмийн гаж нөлөөний талаарх мэдээллийн эх үүсвэр (хувиар)



Иргэдийн 54% нь өөрөө уншиж судлан эмийн гаж нөлөөний талаар мэдлэгтэй болдог ба 40% нь найз нөхөд, 6% нь гэр бүлийн гишүүдээс мэдээлэл авдаг байна.




Зураг 10. Эрүүл мэндийн ажилтны эмийн гаж нөлөөний талаарх мэдээллийн эх үүсвэр (хувиар)



Нийт судалгаанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүдийн дийлэнх буюу 80.6% нь эмийн хэрэглэх заавраас, 19.4% нь эмийн компаниас гаргасан танилцуулга, гарын авлаганаас эмийн гаж нөлөөний тухай мэдээллийг авдаг байна.

Зураг 11. Иргэдэд эмийн гаж нөлөөний талаарх мэдээлэл өгөх мэдээллийн эх үүсвэр (хувиар)



Иргэд нь эмийн хэрэглэх заавраас эмийн гаж нөлөөний талаарх мэдээллийг авах нь дөхөм гэж эмнэлгийн мэргэжилтнүүдийн 96% нь үзсэн байна.


*Шигтгээ: Эмийн гаж нөлөө гарах хэд хэдэн шалтгаан байж болно.*

*Эм бэлдмэл, эмийн хэлбэрээс шалтгаалсан бол эм зүйч нарын буруу*

*Эмийг буруу өгсөн, буруу хийсэн бол эмч, сувилагчийн буруу*


*Эмийг стандартын дагуу олгосон боловч өвчтнөөс өөрөөс нь шалтгаалсан байж болно*

**Зураг 12. Иргэдийн эмийн гаж нөлөөний талаар мэдээлэл авахыг хүссэн мэдээллийн эх сурвалж (хувиар)**




Иргэдийн 61% нь эмийн гаж нөлөөний талаарх мэдээллийг эмч, сувилагч, эмийн санч зэрэг эмнэлгийн ажилчдаас бүгдээс нь авахыг илүүд үзсэн байна.

**Зураг 13. Иргэдийн эмийн гаж нөлөөг мэдээлбэл зохих байгууллага (хувиар)**




Иргэд нь эмийн гаж нөлөөг харьяа өрхийн эрүүл мэндийн төвд мэдээлэх хэрэгтэй гэж судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилчдын 51.5%, үйлчлүүлсэн эмийн санд мэдээлэхийг эмнэлгийн ажилчдын 47,6% нь илүүд зүсэн байхад тэдний 1% нь хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр анхааруулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Зураг 14. Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн хуудасны чанар




Судалгаанд хамрагдсан эмч, эмнэлгийн ажилчдын 42% нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны 89 дугаар тушаалаар шинэчлэгдэн батлагдсан “Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн хуудас ”шаардлага хангаж байна” гэж үзсэн бол 39% нь шаардлага хангахгүй, 19% нь “энэ талаар мэдэхгүй” гэсэн байна.

Зураг 15. Иргэдийн эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн хуудасны талаарх мэдлэг (хувиар)




Иргэдийн дийлэнх буюу 90% нь эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн хуудсыг мэдэхгүй байгаа нь эрүүл мэндийн ажилтнуудын зүгээс тэдэнд хангалттай мэдээлэл өгөхгүй байгаатай холбоотой байж болно.

Зураг 16. Эмийн гаж нөлөөг бүртгэхэд тулгардаг саад, бэрхшээл (хувиар)




Судалгаанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүдэд (96%) эмийн гаж нөлөөг бүртгэж, мэдээлэхэд ямар нэгэн саад, бэрхшээл тулгардаггүй байна.

Зураг 17. Эм худалдан авч буй иргэнд эмийн хүчинтэй хугацааг анхааруулдаг эмнэлгийн ажилтан (хувиар)




Судалгаанд хамрагдсан эмийн санчдын 23% нь иргэдэд эмийн хүчинтэй хугацааг хэлдэггүй, 22% нь хааяа л энэ талаар мэдээлэл өгдөг байна.

Зураг 18. Эмийн заавар бичигдсэн хэл (хувиар)




“Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 18.5 заалтын дагуу эмийн заавар нь монгол хэл дээр бичигдсэн байх ёстой. Худалдаанд буй зарим эмийн бэлдмэл монгол зааваргүй гэж судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны 35% нь хариулжээ.

Зураг 19. Эмийн заавар бичих хэлний талаарх иргэдийн мэдлэг (хувиар)




Судалгаанд хамрагдсан иргэдийн 25% нь л эмийн хэрэглэх заавар монгол хэл дээр байх ёстойг мэддэг, 75% нь энэ талаар мэдэхгүй байна.

Зураг 20. Монгол хэлээр бичигдсэн эмийн заавар шаарддаг иргэд (хувиар)



Судалгаанд хамрагдсан иргэдийн 38% нь монгол хэл дээр бичигдсэн эмийн хэрэглэх зааврыг шаарддаг, 60% нь огт нэхдэггүй байна. Худалдаанд буй эмийн хэрэглэх заавар монгол хэл дээр байх ёстойг иргэд тэр бүр мэддэггүй болох нь харагдаж байна.

Зураг 21. Иргэдийн эмийн заавраас авдаг мэдээллийн төрөл (хувиар)



Судалгаанд хамрагдсан иргэдийн 19% нь эмийн заавраас эмийн гаж нөлөөний талаар мэдээллийг авдаг ба заавраас эмийг хэрэглэх аргыг мэдэхэд түлхүү ашигладаг байна.

2018 онд Эрүүл мэндийн Хөгжлийн төвийн эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээний санд нийт 12 байгууллагаас 81 эмийн гаж нөлөө бүртгэгдсэнээс төрийн өмчит 7 эрүүл мэндийн байгууллагаас 60 тохиолдол (74%), хувийн хэвшлийн 5 эрүүл мэндийн байгууллагаас 21 (26%) эмийн гаж нөлөөний тохиолдлыг бүртгүүлсэн байна.

**Хүснэгт 4. Эрүүл мэндийн Хөгжлийн төвийн эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээний сангийн үзүүлэлт**

№	Эрүүл мэндийн байгууллага	Бүртгүүлсэн эмийн гаж нөлөөний мэдээллийн тоо
1	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	13
2	Халдварт өвчин судлалын үндэсний төв	30
3	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	5
4	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	6
5	Орхон аймгийн эрүүл мэндийн газар	1
6	Дундговь аймгийн эрүүл мэндийн төв	1
7	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв	4
8	Интермед эмнэлэг	6
9	Интернейшнл медикал центр	4
10	Мөнгөн гүүр эмнэлэг	2
11	Сөүл сениорс товер ХХК	6
12	Энто ХХК	3
	<b>Бүгд</b>	<b>81</b>

**ДҮГНЭЛТ:**

1. Судалгаанд нийслэлийн 6 дүүргийн төрийн өмчит болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нийт 206 ажилтан хамрагдсаны 36% нь эм найруулагч, 22% нь сувилагч, 21% эм зүйч, 21% их эмч байлаа.
2. Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажиллагсад нь эмийн гаж нөлөө болон түүний улмаас хүний биед учрах хор хөнөөлийг мэддэг нь сайшаалтай байна. Тэдний 81% нь эмийн хэрэглэх заавар, 19% нь эмийн компаний бэлтгэсэн танилцуулга, гарын авлагаас эмийн гаж нөлөөний талаар мэдээлэл авдаг байна
3. Судалгаанд хамрагдсан иргэдийн 15% нь эмийн гаж нөлөөний талаар мэддэг, 85% нь эмийн гаж нөлөөний талаар ямар нэгэн мэдлэггүй байв
4. Эрүүл мэндийн ажиллагсдын 25% нь үйлчлүүлэгчдэд эмийн гаж нөлөөний талаар тогтмол мэдээлэл өгдөг байхад 72%-нь заримдаа, 3% нь тэр талаар мэдээлэл өгдөггүй нь эрүүл мэндийн ажилтнуудын дунд эмийн гаж нөлөөний талаарх мэдээлэл түгээх байдал харилцан адилгүй байгааг харуулж байна.
5. Худалдаанд буй зарим эмийн бэлдмэл монгол зааваргүй байдаг гэж судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны 35% нь хариулснаас харахад “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн заалт хэрэжихгүй байгааг харуулж байна.
6. Судалгаанд хамрагдсан иргэдийн 38% нь монгол хэл дээр бичигдсэн эмийн хэрэглэх зааврыг шаарддаг, 60% нь энэ талаар огт лавладаггүй байна. Худалдаанд буй эмийн хэрэглэх заавар монгол хэл дээр байх ёстойг иргэд тэр бүр мэддэггүй болох нь харагдаж байна.

7. Иргэдийн дийлэнх буюу 90% нь эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн хуудсыг мэдэхгүй байгаа нь эрүүл мэндийн ажилтнуудын зүгээс тэдэнд хангалттай мэдээлэл өгөхгүй байгаатай холбоотой байж болно. Эрүүл мэндийн ажиллагсдын дөнгөж 30% нь эмийн гаж нөлөөний аюулгүй байдлыг мэдээллэх шар хуудсыг бөглөх талаар үйлчлүүлэгчдэд зөвлөсөн байна.
8. Эрүүл мэндийн Хөгжлийн төвийн эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээний санд 2018 онд нийт 12 байгууллагаас нийт 81 эмийн гаж нөлөө бүртгэгдсэний 74% төрийн өмчит, 26% нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас бүртгэгдсэн нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд эмийн гаж нөлөөг харьцангуй бага мэдээлж байгаа нь харагдаж байна.
9. Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны 20% нь эмийн гаж нөлөөтэй холбоотой гомдлыг иргэдээс хүлээн авчээ.
10. Эмч, эмнэлгийн ажилчдын 39% нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны 89 дугаар тушаалаар шинэчлэгдэн батлагдсан “Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн хуудас ” нь шаардлага хангахгүй байна” гэж дүгнэжээ.
11. Эмийн гаж нөлөө илэрсэн иргэд нь харъяа өрхийн эрүүл мэндийн төвд энэ талаар мэдээлэх нь зүйтэй гэж эмнэлгийн мэргэжилтнүүдийн 51.5%(106), үйлчлүүлсэн эмийн санд мэдээлэх нь зүйтэй гэж судалгаанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүдийн 47.6% (98), 1% нь хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнд мэдээлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

#### САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

- Эмийн гаж нөлөөний улмаас эмчлүүлэгч хөгжлийн бэрхшээлтэй болох, төрөлхийн гажиг үүсэх, удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлэх, хөдөлмөрийн чадвар алдах явдал ихсэж байгаа өнөө үед эрүүл мэндийн ажиллагсад нь эмийн гаж нөлөөг бүртгүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, эмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, мэдээллийг иргэдэд тогтмол өгч хэвших шаардлагатай байна.
- Эмийн гаж нөлөө бүрийг бүртгэх талаар эрүүл мэндийн байгууллага, ялангуяа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд анхаарч ажиллах